



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/713

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е" заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Манхан сумын Соёлын төв үүсэн байгуулагдсаны түүхт 90 жилийн ойг тохиолдуулан ардын болон сонгодог урлагийг орон нутгийн иргэдэд хүргэх, олон угсаатны өв, соёлыг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх үйлсэд өөрийн авъяас чадвараа дайчлан ажиллаж буй Соёлын төвийн дуу хөгжмийн багш Э.Гомбожавыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан Э.Гомбожавд 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Манхан сумын Соёлын төвийн эрхлэгч /Х.Цэрэнбадам/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ